



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 7/242

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 4.5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын орлогоос гүйцэтгүүлсэн Зөрүүлэг багийн Намгийн булгийн эх хаших, Онгоцотын эхэн усны булгийн эх хаших, Бүрдний булгийн эх хаших ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Гишүүд: Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авч, ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Пүрэвтогтох)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Зөрүүлэг багийн Намгийн булгийн эх хаших, Онгоцотын эхэн усны булгийн эх хаших, Бүрдний булгийн эх хаших ажлыг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ

